Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	1,451.19	0	1,451.19
Тайлант үеийн үр дүн	0	0	7,324,374.65	7,324,374.65
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,128,402.07	23,446,610.51	37,595,321.83	124,170,334.40
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	63,128,402.07	23,446,610.51	37,595,321.83	124,170,334.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	960,951.28	153,305.83	586,288.24	1,700,545.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,089,353.35	23,599,916.34	38,181,610.07	125,870,879.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-53,376.57	17,806,053.92	42.92	17,752,720.26
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	848,337.00	2,511,727.20	-674,802.13	2,685,262.07
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	14,202.83	54,607.07	-1,621.88	67,188.02
Өмчид гарсан өөрчилөлт	1,428,002.43	92,919.06	0	1,520,921.49
Зарласан ногдол ашиг	0	15.74	0	15.74
Тайлант үеийн үр дүн	10,682,937.32	4,665,253.66	-9,791,922.30	5,556,268.68
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,009,456.35	48,730,492.98	27,697,198.76	153,437,148.09

2.5. Аудит хийгдсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,580,126.50	61,826,343.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,138,906.80	50,621,316.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,710,137.20	41,556,424.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,456,200.70	23,267,352.02
210101	Үндсэн цалин	18,042,190.20	18,017,548.91
210102	Нэмэгдэл	2,715,414.30	2,706,336.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	175,219.60	160,590.72
210104	Урамшуулал	1,339,903.20	1,225,791.03
210105	Гэрээт ажлын хөлс	1,183,473.40	1,157,084.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,967,314.30	2,920,268.13
210201	Тэтгэврийн даатгал	2,023,721.50	2,132,481.95
210202	Тэтгэмжийн даатгал	226,964.30	188,588.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	191,830.50	162,904.99
210204	Ажилгүйдлийн даатгал	46,337.50	40,203.90
210205	Эрүүл мэндийн даатгал	478,460.50	396,089.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,019,307.30	4,999,973.57
210301	Гэрэл, цахилгаан	440,168.00	418,236.66
210302	Түлш, халаалт	4,153,444.10	4,175,359.03
210303	Цэвэр, бохир ус	409,534.00	397,608.59
210304	Байрны түрээс	16,161.20	8,769.30
2104	Хангамж, бараа материалын зардал	1,295,610.70	1,298,579.63
210401	Бичиг хэрэг	128,726.40	137,693.79
210402	Тээвэр, шатахуун	602,038.60	597,850.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,049.80	131,028.31
210404	Ном, хэвлэл	27,815.00	23,122.27
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	221,514.30	219,094.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	178,466.60	189,789.85
2105	Нормативт зардал	1,748,899.50	1,737,567.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,876.80	189,983.08
210502	Хоол, хүнс	1,440,241.90	1,430,605.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	117,780.80	116,978.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,083,723.10	2,053,440.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	361,201.00	333,493.32
210602	Тавилга	278,097.30	284,170.49
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,058.00	13,197.18
210604	Урсгал засвар	1,433,366.80	1,422,579.81
2107	Томилолт, зочны зардал	176,678.10	169,717.88
210702	Дотоод албан томилолт	158,137.80	151,641.21
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18,540.30	18,076.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,564,140.90	3,249,140.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,506,707.40	3,198,759.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,903.80	10,791.83
210803	Даатгалын үйлчилгээ	20,314.90	19,030.93
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,264.30	8,644.98
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,980.90	3,021.93
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15	226.9
210807	Газрын төлбөр	4,668.60	4,046.87
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,286.00	4,618.22
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,398,262.60	1,860,384.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,087,535.90	1,541,728.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	310,726.70	318,655.49

212	ТАТААС	490,965.70	490,965.70
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	490,965.70	490,965.70
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	490,965.70	490,965.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,937,803.90	8,573,926.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,124,099.80	2,124,099.80
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,124,099.80	2,124,099.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,813,704.10	6,449,826.88
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0	-1,020.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,456,457.00	5,115,705.66
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,240.00	2,226.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	626,631.60	616,088.57
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	239,581.60	229,217.59
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	475,526.90	463,307.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,267.00	24,300.68
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,441,219.70	11,205,026.37
220001	Барилга байгууламж	7,591,554.60	7,286,894.84
221001	Их засвар	624,000.00	651,132.15
223001	Бусад хөрөнгө	3,225,665.10	3,266,999.38
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,580,126.50	62,311,319.20
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,183,313.00	34,011,461.78
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	30,907,705.30	30,732,940.51
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,275,607.70	3,278,521.27
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,835,740.20	26,847,838.80
320001	Орон нутгийн төсвөөс	26,835,740.20	26,847,838.80
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,561,073.30	1,450,547.83
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	947,343.70	916,222.05
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	365,295.70	534,325.78
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,248,433.90	0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0	1,470.78
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0	1,470.78
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	1,023,981.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,508,957.57
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	23,971.00	22,599.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	197	197
610001	Төсвийн байгууллага	195	195
610002	Төсвөөс гадуур байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,062.00	2,948.00
620001	Удирдах ажилтан	231	223
620002	Гүйцэтгэх ажилтан	1,694.00	1,627.00
620003	Үйлчлэх ажилтан	883	877
620004	Гэрээт ажилтан	254	221
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	18,059.00	16,506.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	12,705.00	11,443.00
630001	Төрийн өмчит ЕБС	12,529.00	11,267.00
630002	Хувийн ЕБС	176	176
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	5,354.00	5,063.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	5,004.00	4,713.00
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	350	350

3. АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.3. Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн (ТЕЗ) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

3.4. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим бөгөөд хамарсан асуудлууд болно.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, зарим төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТТЗ-ийн 14, ОН-ийн төсвийн шууд захирагчийн 39, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 87, тусгай сангийн 43, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 7, төсвөөс татаас авдаг 3 хувийн цэцэрлэг, төсөвт байгууллагын харьяа ахмадын сангийн 42 байгууллага нийт 235 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамрууллаа.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 –т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.” гэж заасны дагуу 100 хувийн орон нутгийн өмчит 7 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг бүрэн хамруулсан байна.

3.3. Аудитын арга зүй

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил,

шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

3.4. Материаллаг байдлын түвшин

Дорноговь аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт цэвэр хөрөнгийн дүнг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 1,534.7 сая төгрөгөөр тогтоов.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Аймгийн ТЭЗ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн 8.9.4-т заасан хугацаанд ирүүлэх учиртай. Гэтэл тайланг хуулийн хугацаанаас 9 хоногоор хоцроож 2019.04.09-ний өдөр Төрийн аудитын газарт ирүүллээ.

Нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал"-ыг баримтлан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-д заасны дагуу дараах байдлаар бэлтгэсэн:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллага хооронд үүссэн 14,170.0 сая төгрөгийн давхардсан ажил гүйлгээ, орлого болон зардлыг цэвэрлэж тайлагнасан;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллага, сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрлөөр ангилан тайлагнасан байна.

4.1. Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Аймгийн ТЭЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

4.2. Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

4.3. Санхүүгийн тайлангийн бүтэц, бэлтгэсэн суурь

Аймгийн ТЭЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах зорилтын хүрээнд үе шаттай ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Дорноговь аймгийн ТЭЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн

болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу Сангийн яамны "Э-тайлан" программ системд бэлтгэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	НББ-ийн зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	

4.4. Нягтлан бодох бүртгэлийн зарчим

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдсэн байна. Үүнд:

- Кассанд байгаа бэлэн мөнгө;
- Төрийн сангийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;

Мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө нь богино хугацаатай, өндөр хөрвөх чадвартай хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хөрөнгө байна.

Авлага

Авлага нь богино хугацаат дансны авлага, зээлийн авлага болон урьдчилгаанаас бүрдэнэ.

Урт хугацаат зээлийн авлага

Урт хугацаат зээлийн авлага нь Засгийн газрын байгууллагуудын бусдад нэг жилээс дээш хугацаанд зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийн жилийн эцэст төлөгдөөгүй байгаа үлдэгдэл дүнг илэрхийлнэ. Зээлийн авлагыг төлөгдөх дүнгээр нь хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материал

Бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар тодорхойлжээ.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь болон Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаал, 2018 оны 207 дугаар тушаалуудаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд

хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу төсөвт байгууллагын үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр хүлээн зөвшөөрсөн.

Төсвийн захирагчид 2018 онд үндсэн хөрөнгөд УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" стандартын дагуу элэгдэл байгуулжээ.

Биет бус

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй боловч ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага юм.

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалуудаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу төрийн байгууллагуудын эзэмшлийн газрыг үнэлэн бүртгэн тайлагнасан.

Богино хугацаат өр

Богино хугацаат өр төлбөр нь нэг жилийн дотор барагдуулах ёстой өр төлбөрийг илэрхийлнэ.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд барагдуулах үүрэг хариуцлага юм.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Арилжааны бус орлого болох татвар, хураамж, торгууль, шимтгэлийг цуглуулсан үед нь, харин бараа, үйлчилгээг төлбөртэйгөөр хүргэсэн үед арилжааны (хэрэгжсэн) орлогыг тохируулсан аккруэл сууриар хүлээн зөвшөөрсөн байна.

Зардал

Нягтлан бодох бүртгэлийн аккруэл зарчмын дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрсөн байна.

4.5. Дотоод аудит

Төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69.2-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана." гэж заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба болон аймгийн Төрийн сангийн дотоод аудитын нэгж санхүүгийн үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар ханган ажилладаг байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2018 онд Аймгийн Засаг даргын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу харьяа санхүүгийн алба болон төрийн санд өдөр тутмын хяналтыг, 6 сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод хяналт, шалгалтыг хийсэн байна. Дотоод хяналт шалгалтаар Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн төлбөр тооцооны журам", Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын удирдлага мэдээллийн системд мөрдөх журам" зэргийн холбогдох

заалтуудыг зөрчин төлбөр тооцоог гүйцэтгэсэн алдаа зөрчлүүдийг илрүүлж, гарсан алдаа зөрчилд заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 онд нийт 56 байгууллагад төлөвлөгөөт шалгалт, 12 байгууллагад төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалт, 7 байгууллагад дотоод аудитыг хийж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг албан тоотоор хүргүүлсэн байна.

Мөн Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 3 байгууллагын 2016-2017 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Тайлант онд хийсэн хяналт шалгалтын явцад нийт 977.4 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, холбогдох байгууллагуудад хугацаатай акт, албан шаардлага өгч, 857 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тухайн тайлант хугацаанд хийгдсэн хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Албан томилолтын хоногийг засаж, илүү дутуу олгосон, анхан шатны баримтын бүрдлийг хангадаггүй /Засгийн газрын 218-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан журмын 12-р заалт/
- Автомашины шатахууны зарцуулалтыг тооцохдоо нормоос илүү бодож олгосон ба замын хуудсыг бөглөдөггүй /Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан жишиг норм /
- Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны хувьд зарим байгууллага нь дотоод хяналтыг огт хийдэггүй, зарим байгууллага нь хяналт шалгалт хийсэн боловч шаардлага хангахгүй санхүүгийн үйл ажиллагаандаа бус үндсэн үйл ажиллагаандаа хяналтыг хэрэгжүүлдэг /ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол /
- Удирдлагууд хүчингүй болсон хууль тогтоомжийг тушаал шийдвэрийн үндэслэл болгосон
- Ажлаас халагдсан ажилтнуудтай ээлжийн амралтын тооцоо хийдэггүйгээс ээлжийн амралтын олговор дутуу олгодог, мөн ээлжийн амралтын мөнгийг давхардуулан тооцож олгосон /Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1 дэх заалт/
- Ажилчдад цалингийн урьдчилгаа бодож олгохдоо цалингаас давсан хэмжээгээр олгодог боловч тухайн сард цалин хүрэлцэхгүй бол өглөг, авлагаар тусгадаггүйгээс ажилчдаас авах авлагаа дутуу суутгах /НББТХ-ийн 14.4.2 дахь заалт/
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, үндсэн хөрөнгөө коджуулаагүй, элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох газарт нь санал хүргүүлж шийдвэрлүүлдэггүй /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 зүйл /
- Шагнал урамшуулал олгохдоо ХХОАТ суутгадаггүй /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 16.1.1, 23.1, 26.1.1 дэх заалтууд/
- Эрх зүйн актгүй байхад цалингийн нэмэгдэл бодож олгосон
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн

Дээрх зөрчлүүдийн улмаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, холбогдох журам, зааврууд зөрчигдсөөр байна.

Төсвийн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй, алдаа зөрчлийг давтсаар байгаа нь дотоод аудитын алба харьяа байгууллагуудынхаа санхүүгийн үйл ажиллагааг шалгах, зөрчлийг илрүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах зэрэг үйл ажиллагаа хангалтгүй хийж байгаа, сургалт мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна.

4.6. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуульд төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан байна.

Аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллагууд хуульд заасан дээрх мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж байгаа бөгөөд хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллага, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт тавьж ажилласан байна.

Санхүүгийн хяналт аудитын албанаас ХАА-наас 2018 оны 01 дүгээр сараас 10 дүгээр сар хүртэл төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, сан зэрэг 14 сумын 132, аймгийн төвийн 16 нийт 148 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулсан эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллан, шалгалтын материал, цаашид авах арга хэмжээний саналыг Сангийн яам болон аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн ажилласан байна.

Нийт шалгалтад хамрагдсан төсвийн 148 байгууллагын 16220 мэдээлэл цахим хуудсанд байршихаас 14030 мэдээллийг хугацаанд нь, 2013 мэдээлэл хугацаа хоцроож, 137 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, огт мэдээлээгүй байгууллага, албан тушаалтнуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авхуулах саналыг удаа дараа аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүйгээс мэдээллийг огт байршуулдаггүй, хугацаа хоцроодог байдал өмнөх оны мөн үес буурсан боловч зарим байгууллагын хувьд байсаар байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах, байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнуудыг нэгдсэн нэг ойлголттой болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТТЗ, орон нутгийн төсөвт байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллага, төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл, сангуудын нийт 235 байгууллагын тайланг нэгтгэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсарч ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан байхад Дорноговь аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 4-р сарын 09-ны өдөр нь ирүүлсэн.

Ирүүлсэн аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь байгууллага хоорондын тооцоо, төсвийн тохируулгыг хийгээгүй балансын болон орлого зарлагын дансдын бүртгэл давхар тайлагнагдсан, данс бүртгэлийг буруу ангилан бүртгэсэн, санхүүжилт, зарцуулалтын тооцоолол зөрүүтэй нэгтгэгдсэн зэрэг алдаа зөрчилтэй нэгтгэсэн байлаа.

Аудитын явцад нэгтгэсэн санхүүгийн тайланд 3 удаа засвар, өөрчлөлт оруулсан бөгөөд ОНХС, ОНХО-ын тайланг бэлтгэхдээ холбогдох мэргэжилтнүүдтэй тооцоо нийлээгүйгээс зөрүүтэй тайлан ирүүлсэн, түүнийг залруулж 2019 оны 04-р сарын 24 өдөр 3/765 тоот албан бичгээр аудитын байгууллагад ирүүлээ.

Энэ нь аймгийн төсвийн Ерөнхий нягтлан бодогч 2018 оны 10 дугаар сард чөлөөлөгдөж, дадлага туршлага хангалтгүй хүнээр түр орлон гүйцэтгүүлж байгаатай холбоотой бөгөөд аудит хийхэд хүндрэлтэй байсан болно.

5.1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь мөнгөн хөрөнгө 4,117.2 сая төгрөг, авлага болон урьдчилгаа 7,437.9 сая төгрөг, бараа материал, нөөц, бусад эргэлтийн хөрөнгө 7,009.3 сая төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 40.6 сая төгрөг, цэвэр үндсэн хөрөнгө 139,638.3 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 2,955.0 сая төгрөг, урт хугацаат өр төлбөр 1,851.1 сая төгрөг, цэвэр хөрөнгийн өмчийн дүн 153,437.1 сая төгрөг нийт 158,243.2 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 30,447.1 сая төгрөг буюу 23.8 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оноос мөнгөн хөрөнгө 1,324.2 сая төгрөг, авлага 1,525.0 сая төгрөг, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө 961.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж урьдчилж төлсөн зардал 3,799.1 сая төгрөг, нөөцийн бараа 7.0 сая төгрөгөөр тус тус буурч эргэлтийн хөрөнгө нийт дүндээ 4.7 сая төгрөгөөр буюу 0.03 хувиар өссөн байна.

Нийт өр төлбөр 1,180.3 сая төгрөг буюу 32.3 хувиар өссөн нь богино хугацаат өр төлбөр 1,180.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлант нийт хөрөнгийн 11.7 хувийг эргэлтийн хөрөнгө, 88.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө, 3 хувийг нийт өр төлбөр, 97 хувийг цэвэр хөрөнгө эзэлж байна.

Өмнөх оноос нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь Эргэлтийн хөрөнгө 2.8 хувиар, цэвэр хөрөнгө 0.8 хувиар буурч, эргэлтийн бус хөрөнгө 2.8 хувиар, нийт өр төлбөр 0.2 хувиар өссөн байна. /График-1, 2 үзүүлэв/



5.2. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар нийт орлого 83,395.5 сая төгрөг нийт зардал нь 93,187.4 сая төгрөг үйл ажиллагааны нийт үр дүн -9,791.9 сая төгрөг болж алдагдалтай гарсан байна.

2018 онд хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж үйл ажиллагааны бус зардалд хөрөнгийн дахин үнэлгээний зардал 10,427.6 сая төгрөгөөр бүртгэгдэж, орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 501.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.

Тайлант онд урсгал зардал өмнөх оноос 20,177.6 сая төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний зардал 19,760.7 сая төгрөг, урсгал шилжүүлэг 416.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

5.3. Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Дорноговь аймгийн ТЕЗ-ын 2018 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланд засгийн газрын хувь оролцоо 29,266.8 сая төгрөг буюу 23.5 хувиар нэмэгдсэн нь хөрөнгийн дахин үнэлгээний дүнд Засгийн газрын оруулсан капитал, хөрөнгийн дахин үнэлгээгээр зөрүү нэмэгдсэнтэй холбоотой байна.

5.4. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Дорноговь аймгийн ТЕЗ-ын 2018 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,793.0 сая төгрөг, нийт орлого 88,253.6 сая төгрөг нийт зардал 86,929.4 сая төгрөг эцсийн үлдэгдэл 4,117.2 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт орлогод үйл ажиллагааны мөнгөн орлого 87,079.1 сая төгрөг буюу 98.7 хувийг, хүлээн авсан хүүгийн орлого 33.2 сая төгрөг буюу 0.04 хувийг, арилжааны банкнаас авсан зээл 1,141.3 сая төгрөг буюу 1.3 хувийг,

Нийт зардалд үйл ажиллагааны зардал 67,823.9 сая төгрөг буюу 78.0 хувийг, хөрөнгийн зардал 18,843.5 сая төгрөг буюу 21.7 хувийг, арилжааны банкны зээлийн төлбөрт 262.0 сая төгрөг буюу 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Үйл ажиллагааны орлого өмнөх оноос 14,408.2 сая төгрөг буюу 19.8 хувиар, үйл ажиллагааны нийт зардал 8,155.4 сая төгрөг буюу 13.7 хувиар, хөрөнгийн

Аудитын илрүүлэлт:

- *Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-д заасны дагуу тодруулга бүрд тайлбар, тэмдэглэлийг бүрэн хийгээгүй байна*

6. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН, ЗАЛРУУЛГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

6.1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 4,117.2 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 1,324.2 сая төгрөг буюу 47.4 хувиар өссөн ба нийт хөрөнгийн 2.6 хувийг эзэлж байна.

Нийт мөнгөн хөрөнгийн 76.26 хувь нь Төрийн сан, 23.5 хувь нь арилжааны банканд, 0.24 хувь нь байгууллагуудын кассат бэлнээр тус тус байршсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/мян.төг/ Дүнд эзлэх хувь
Кассанд байгаа бэлэн мөнгө	10,516.5	9,806.5	-710.0	0.24
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,782,485.7	4,107,375.4	1,324,889.7	99.76
- Төрийн сангийн харилцах	1,926,688.8	3,139,822.9	1,213,134.1	76.26
- Арилжааны банкны харилцах	855,796.9	967,552.5	111,755.6	23.5
Нийт дүн	2,793,002.2	4,117,181.9	1,324,179.7	100.0

6.3.1. Аймгийн төрийн сан болон аймгийн төвийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ын мөнгөн хөрөнгө

Дорноговь аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа аймгийн төвийн ТШЗ-ийн нийт мөнгөн хөрөнгө үлдэгдэл өмнөх оноос 776.7 сая төгрөг буюу өөр нэмэгдэж 1,585.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	808,699.60	1,585,411.40	776,711.80
Төгрөг	808,699.60	1,585,411.40	776,711.80
Төрийн сан банк	808,405.30	1,585,411.40	777,006.10
Арилжааны банк дахь харилцах	294.3		(294.30)
Касс дахь бэлэн мөнгө			-
Нийт дүн	808,699.60	1,585,411.40	776,711.80

6.3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийн 30.8 хувь, эцсийн үлдэгдлийн 23.6 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2018 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 112.9 сая төгрөг буюу 13.1 хувиар өсч, 972.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	848,941.80	962,528.70	113,586.90
Төгрөг	848,941.80	962,528.70	113,586.90
Төрийн сан банк			-
Арилжааны банк дахь харилцах	848,941.8	962,528.70	113,586.90
Касс дахь бэлэн мөнгө	10,516.50	9,806.50	(710.00)
Нийт дүн	859,458.30	972,335.20	112,876.90

6.3.3. Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын мөнгөн хөрөнгө

Сумын ТТЗ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 434.6 сая төгрөг буюу 38.6 хувиар өсөн 1,559.4 сая төгрөгийн үлдэгдэл 100 хувь харилцах дансанд байршиж байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,124,844.20	1,559,435.30	434,591.10
Төгрөг	1,124,844.20	1,559,435.30	434,591.10
Төрийн сан банк	1,124,720.90	1,554,411.60	429,690.70
Арилжааны банк дахь харилцах	123.3	5023.7	4,900.40
Касс дахь бэлэн мөнгө			-
Нийт дүн	1,124,844.20	1,559,435.30	434,591.10

6.4. Авлага, урьдчилгаа

6.4.1. Авлага

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 5,849.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,374.9 сая төгрөгөөр тайлагнаж өмнөх онтой харьцуулахад 1,525.0 сая төгрөгөөр буюу 26.1 хувиар өссөн байна.

Нийт авлагын 55.2 хувь нь сумдын ТТЗ-ийн авлага, 42.1 хувь нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага, 2.6 хувь нь Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн байгууллагын авлага байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
			дүн	хувь
Нийт авлага	5,849,913.70	7,374,897.40	1,524,983.70	26.07
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн авлага	91,315.80	193,236.90	101,921.10	111.61
Сумдын ТТЗ	4,312,026.00	4,072,526.90	-239,499.10	-5.55
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	1,446,571.90	3,109,133.60	1,662,561.70	114.93

Нийт авлагын дүнд ажилчдтай холбоотой авлага 41.1 сая төгрөг буюу 0.6 хувийг, татаас санхүүжилтийн авлага 50.6 сая төгрөг буюу 0.6 хувийг, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 3463.8 сая төгрөг буюу 47 хувийг, байгууллагаас авах авлага 581.7 сая төгрөг буюу 7.9 хувийг, ТӨҮГ-ийн данс болон Татвар НДШ-ийн авлага 3,088.8 сая төгрөг буюу 41.9 хувийг, бусад зардлын тооцооны авлага 148.9 сая төгрөг буюу 2 хувийг эзлэж байна.

Аудитын илрүүлэлт:

- ЖҮДС-аас хувийн хэвшилд олгосон 60.0 сая төгрөгийн зээлийн авлага, Хандивын сангийн байгууллагаас авах авлага 21.0 сая төгрөг, нийт 81.0 сая төгрөгийн зээл нь 2013 оноос өмнө үүсч олон жилийн насжилттай, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Аймгийн ОНХСангаас ОНХО-ын дансад залруулгыг 2 дахин хийснээс үүсэн 34.1 сая төгрөгийг ОНХС-д авлагаар бүртгээгүй байна. Аудитын явцад залруулан бүртгэсэн.

6.4.2. Урьдчилгаа

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 3,862.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 63.0 сая төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 3,799.1 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт урьдчилгаа дансны 71.6 хувь буюу 45.1 сая төгрөг нь урьдчилж гарсан зардал байна.

Урьдчилгаа дансыг байгууллагын төрлөөр авч үзвэл орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урьдчилгаа 10.9 сая төгрөг, төсөвт байгууллагын урьдчилгаа 52.1 сая төгрөг / хөрөнгө бэлтгэхдээ холбоотой үүссэн/ урьдчилгаа байна.

6.5. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 40.6 сая төгрөг тайлант оны эцэст өөрчлөлт ороогүй байна.

Нийт урт хугацаат хөрөнгө оруулалтын 1,841.4 сая төгрөгийн урт хугацаат зээл байна. Уг зээлийг аймгийн Төрийн сан болон Чандмань илч ОНӨХХК хоорондын тооцоогоор тохируулан устгах бичилтийг хийж цэвэрлэдэг байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүү, эдийн засгийн яам /хуучин нэрээр/ Дорноговь аймгийн ЗДТГ хооронд 2003 онд 1.8 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж, тус хөрөнгийг “Чандмань илч” ХХК-д дамжуулан зээлдүүлсэн ч эргэн төлөлт хийгдээгүй байна.
- Урт хугацаат зээлийг хоорондын тооцоогоор тохируулалгүй тайланд нэгтгэж Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө болон өр төлбөрийн дүнг 1,841.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Хоорондын тооцоогоор устгах бичилт хийлгэж санхүүгийн тайланд залруулан бүртгэсэн.

6.6. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө

6.6.1. Бараа материал

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл 6,023.5 сая төгрөг байснаас 394.6 сая төгрөгөөр өсч 6,418.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Нийт бараа материалын 74.2 хувь нь сумдын ТТЗ, 16.5 хувь нь орон нутгийн өмчит хуулийн этгээд, 9.3 хувь нь аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн байгууллагын бараа материалд бүртгэлтэй байна.

Нийт бараа материалын 12.9 хувийг түүхий эд материал, 6.5 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 78.7 хувийг хангамжийн материал, 1,9 хувийг мал амьтад эзэлж байна.

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	(мян.төг) Өсөлт/ бууралт Хувь
Нийт бараа материал	6,023,517.80	6,418,094.90	394,577.10	6.55
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	474,670.40	594,137.20	119,466.80	25.17
Сумдын ТТЗ	4,523,369.30	4,765,030.30	241,661.00	5.34
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	1,025,478.10	1,058,927.40	33,449.30	3.26
1. Түүхий эд материал	689,554.60	825,067.20	135,512.60	19.65
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	483.60	1,213.10	729.50	150.85
Сумдын ТТЗ	663,485.20	823,854.10	160,368.90	24.17
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	25,585.80	-	-25,585.80	(100.00)
2. Бэлэн бүтээгдэхүүн	324,133.60	417,112.80	92,979.20	28.69
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	-	-	-	-
Сумдын ТТЗ	2,055.10	1,004.20	-1,050.90	(51.14)
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	322,078.50	416,108.60	94,030.10	29.19

3. Хангамжийн материал				163,111.50	
	4,889,662.50	5,052,774.00			3.34
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн авлага	474,186.80	592,924.10	118,737.30		25.04
Сумдын ТТЗ			79,010.30		
	3,745,554.60	3,824,564.90			2.11
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	669,921.10	635,285.00	-34,636.10		(5.17)
4. Мал амьтад				2,973.80	
	120,167.10	123,140.90			2.47
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	-	-	-		-
Сумдын ТТЗ	112,274.40	115,607.10	3,332.70		2.97
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	7892.7	7533.8	-358.9		(4.55)

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн 11 сумын сургууль, цэцэрлэгүүд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цай хөтөлбөр, бараа материал бэлтгэхдээ ТБОНӨХБАУХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчиж худалдан авалт хийсэн, бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлогоор тусгахгүй шууд зардлаар бүртгэсэн, нэр төрлийн хөдөлгөөний тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод бүрэн хамруулаагүй зэрэг нийт 516.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

6.6.2. Нөөцийн бараа, Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 567.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба барилгын ажлын зураг, төсвийг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Харин нөөцийн бараа оны эхэнд 31.1 сая төгрөг байсан бөгөөд 7.0 сая төгрөгөөр буурч 24.1 сая төгрөг болсон байна. Энэ нь сумдад өвс бэлтгэлийг нөөцийн бараанд бүртгэж сумын ТТЗ-ийн тайланд тусгагдсантай холбоотой байна.

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
1. Нөөцийн бараа	31,154.6	24,105.9	-7048.7	(22.7)
Сумдын ТТЗ	31,154.6	24,105.9	-7048.7	(22.7)
2. Бусад эргэлтийн хөрөнгө				
Сумдын ТТЗ	-	567,061.8	567,061.8	-
Нийт	31,154.6	591,167.7	560,013.1	

6.7. Үндсэн хөрөнгө

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 109,195.8 сая төгрөг байснаас 30442.4 сая төгрөгөөр өсөж, тайлант оны эцэст 139,638.2 сая төгрөг болсон байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХсангаар 2,451.2 сая төгрөгийн барилга байгууламж, 195.4 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 1,791.7 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, 1,396.8 сая төгрөгийн бусад хөрөнгө бэлтгэж хөрөнгийн бүртгэлд авсан байна.

Үндсэн хөрөнгө 2018 оны хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгээр 48,730.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт хөрөнгийн 93.4 хувийг биет хөрөнгө, 6.6 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн 73,4 хувь буюу 102,409.5 сая төгрөгийн хөрөнгө нь сумдын ТТЗ, 20.6 хувь буюу 28,781.8 сая төгрөгийн хөрөнгө нь орон нутгийн өмчит хуулийн этгээд, 6.0 хувь буюу 8,446.9 сая төгрөгийн хөрөнгө нь Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ –ийн байгууллагад тус тус бүртгэлтэй байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/мян.төг/ өсөлтийн хувь
Үндсэн хөрөнгө	109,195,850.30	139,638,295.20	30,442,444.90	27.88
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	5,916,834.40	8,446,931.00	2,530,096.60	42.76
Сумдын ТТЗ			19,731,025.30	23.86
	82,678,529.30	102,409,554.60		
Орон нутгийн өмчит хуулийн этгээд			8,181,323.00	39.71
Биет хөрөнгө	20,600,486.60	28,781,809.60		
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	109,130,970.10	130,410,878.60	21,279,908.50	19.50
Сумдын ТТЗ	5,890,650.90	7201096.2	1,310,445.30	22.25
	82,650,303.10	97,037,337.50	14,387,034.40	17.41
Орон нутгийн өмчит хуулийн этгээд			5,582,428.80	27.11
Биет бус хөрөнгө	20,590,016.10	26,172,444.90		
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	64,880.20	9,227,416.60	9,162,536.40	14,122.24
Сумдын ТТЗ	26183.5	1245834.8	1,219,651.30	4,658.09
	28226.2	5,372,217.10	5,343,990.90	18,932.73
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	10,470.50	2,609,364.70	2,598,894.20	24,821.11

Биет бус хөрөнгийн нэмэгдсэн шалтгаан нь 2018 онд дахин үнэлгээгээр төсөвт байгууллагын эзэмшлийн газрыг үнэлэн НББ-т тусгаж тайлагнасангай холбоотой.

Аудитын илрүүлэлт:

- Сайншанд сумын 1.2.7-р багийн ажлын алба болон Өрхийн эмнэлэгт 51.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тавилга хэрэгсэл худалдан авахдаа ХАА-ны хуулийг зөрчиж шууд гэрээ байгуулсан байна.

6.8. Өр төлбөр

Нийт өр төлбөр оны эхэнд 3,625.8 сая төгрөг байснаас 1,180.3 сая төгрөгөөр нэмэгдэж 4,806.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Нийт өр төлбөр	5,136,278.40	7,761,088.80	2,624,810.40	100.00
Богино хугацаат өр төлбөр дүн	3,285,211.80	5,910,022.20	2,624,810.40	76.15
Өглөг	1,640,286.90	2,955,011.10	1,314,724.20	38.07
Бусад	1,510,505.40	2,854,709.80	1,344,204.40	36.78
Урьдчилж орсон орлого	134,419.50	100,301.30	(34,118.20)	1.29
Урт хугацаат өр төлбөр дүн	1,851,066.60	1,851,066.60	-	23.85

Нийт өр төлбөрийг төсвийн захирагчдаар ангилан харуулбал: /мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Нийт өр төлбөр	3,625,772.90	4,806,077.70	1,180,304.80	100.00
<i>Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн өр төлбөр</i>	1,873,098.70	1,896,247.60	23,148.90	39.46
<i>ТТЗ</i>	316,568.60	220,083.60	(96,485.00)	4.58
<i>Орон нутгийн өмчит хуулийн этгээд</i>	1,436,105.60	2,689,746.50	1,253,640.90	55.97

Хүснэгтээс харахад нийт өр төлбөрийн 39.5 хувь буюу 220.1 сая төгрөгийн өр төлбөр сумдын ТТЗ, 55.9 хувь буюу 2689.7 сая төгрөгийн өр төлбөр орон нутгийн өмчит хуулийн этгээд, 4.6 хувь буюу 1,896.2 сая төгрөгийн өр төлбөр Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн өр төлбөрийн дүн тус тус байна.

- *Нэгтгэл тайланд Санхүү, эдийн засгийн яам /хуучин нэрээр/ Дорноговь аймгийн ЗДТГ хооронд 2003 онд 1.8 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж, тус хөрөнгийг “Чандмань илч” ХХК-д дамжуулан зээлдүүлсэн 1,841.4 сая төгрөгийг устгал хийлгүй төрийн сан болон Чандмань-Илч ХХК-д давхар бүртгэн өглөг 2 дахин өсгөж тайлагнасныг устгах бичилт хийж залрууллаа.*

Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн тайлангаар өр төлбөрийн 1,851.1 сая төгрөг нь Чандмань-Илч ХХК-д уурын зуухны шинэчлэлийн ажилтай холбоотой Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээл байна.

Нийт өр төлбөрт Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр 55.9 хувийг эзэлж байгаа нь 2018 онд Чандмань-Илч ХХК арилжааны банкнаас 1,141.3 сая төгрөгийн зээл авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ОНХСангаас ОНХО-ын дансанд андууран орж ирсэн гүйлгээг залруулахдаа 34.1 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байх бөгөөд үүнийг өглөг авлагаар тусгаагүй шууд зардалд бичин тайлагнасан байсныг ОНХО-ын тайланд өглөгөөр залруулан бүртгэсэн.

6.9. Засгийн газрын хувь оролцоо

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар засгийн газрын хувь оролцооны нийт хэмжээ тайлант оны эхэнд 124,170.3 сая төгрөг байснаас 29,266.8 сая тэрбум төгрөгөөр өсөж 153,437.1 сая төгрөгт хүрсэн байна.

.Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
			дүн	хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41,199,151.37	47,194,127.28	5,994,975.91	14.55
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	9,426,638.00	15,982,371.97	6,555,733.97	69.54
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	12,502,612.70	13,832,957.11	1,330,344.41	10.64
Хуримтлагдсан үр дүн	37,595,321.83	27,705,069.42	-9,890,252.40	-26.31

Өмнөх үеийн үр дүн	30,270,947.18	37,496,654.66	7,225,707.49	23.87
Тайлант үеийн үр дүн	7,324,374.65	-9,791,922.30	-17,116,296.95	-
				233.69
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,446,610.51	48,730,492.98	25,283,882.47	107.84
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-7,533.60	-7,533.60	-
Засгийн газрын хувь оролцоо	124,170,334.40	153,437,485.15	29,267,150.75	23.57

Хөрөнгийн дахин үнэлгээ зөрүү оны эхэнд 23.4 сая төгрөг байсан бөгөөд оны эцэст 25.3 сая төгрөгөөр нэмэгдэж 153.5 сая төгрөг болж өссөн нь 2018 онд барилга байгууламж, газарт дахин үнэлгээ хийгдсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд 9,791.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь мөн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцооны бүтэц: /Төсвийн захирагчаар/					
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-) дүн хувь		Эзлэх хувь
Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ	10,952,580.60	10,805,963.50	(146,617.10)	(1.34)	7.0
Сумдын ТТЗ	92,562,715.10	113,229,101.90	20,666,386.80	22.33	73.8
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	20,655,038.60	29,402,082.70	8,747,044.10	42.35	19.2
Нийт	124,170,334.30	153,437,148.10	29,266,813.80	23.57	100.0

Засгийн газрын сангийн хувь оролцооны 7.0 хувь буюу 10,805.9 сая төгрөгийг Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ, 73.8 хувь буюу 113,229.1 сая төгрөгийг Сумдын ТТЗ, 19.2 хувь буюу 29402.1 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд тус тус эзэлж байна.

Урьд онтой харьцуулахад Аймгийн төрийн сан болон ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн ЗГ-ын хувь оролцоо 146.6 сая төгрөгөөр буурсан харин Сумдын ТТЗ ЗГ-ын хувь оролцоо 20,666.6 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчит хуулийн этгээд ЗГ-ын хувь оролцоо 8,747.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

6.10. Орлогын бүртгэл тайлагнал

6.10.1. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар:

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны орлого 83,391.0 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлого 4.5 сая төгрөг нийт 83,395.5 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүртгэсэн байна.

Энэ нь өмнөх оноос 23.5 хувь буюу 15,864.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт орлогын нэмэгдсэн дүнд татварын болон татварын бус орлого, хандив тусламжаар үнэ төлбөргүй олгогдсон орлого, төсөвт байгууллагуудын санхүүжилт зэргийн өсөлт нөлөөлсөн байна.

Үр дүнгийн тайлангаарх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мян. төгрөг/	
			Зөрүү Дүн	Хувь

Татварын орлого	21,682,834.22	24,657,267.27	2,974,433.05	13.7
Төсөвт байгууллагын өөрийн орлого	805,374.26	1,700,184.05	894,809.79	111.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,323,096.35	9,974,093.87	3,650,997.52	57.7
Бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого	2,046,583.35	3,232,252.78	1,185,669.43	57.9
ОНӨААТҮГ-ын цэвэр борлуулалт	2,271,537.21	2,705,985.54	434,448.33	19.1
Тусгай зориулалтын шилжүүлэг	29,146,325.10	30,907,705.30	1,761,380.20	6.0
ОНХС-гийн шилжүүлсэн орлого	2,307,007.52	3,275,607.76	968,600.23	42.0
Хөрөнгийн санхүүжилт	1,530,421.74	4,869,016.56	3,338,594.83	218.1
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,080.00	151,480.19	150,400.19	13,925.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,382,446.69	1,917,404.87	534,958.18	38.7
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	33,910.07	4,480.13	(29,429.93)	(86.8)
Нийт дүн	67,530,616.50	83,395,478.32	15,864,861.82	23.5

Хүснэгтээс харахад: Орлогын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад татварын орлого 2,974.4 сая төгрөг буюу 13.7 хувиар, татварын бус орлогууд, орон нутгийн санхүүжилтийн болон нэмэлт санхүүжилтийн орлого, ОНӨААТҮГ-ын орлого, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн орлогууд 434.4-3,651.0 сая төгрөг буюу 19.1%-57.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Тухайлбал: Татварын бус орлого нийт дүнгээрээ өмнөх оноос өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 57.7% буюу 3,651.0 сая төгрөгөөр, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт 218.1% буюу 3,338.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

6.10.2. Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар:

Дорноговь аймгийн 2018 оны орон нутгийн төсвийг аймгийн ИТХ-ын 2017 оны 12-р сарын 01-ны 06/02 тогтоолоор баталсан байна. Улмаар 2018 оны 12 дугаар сард аймаг, сумын ИТХ-аар төсвийг тодотгосон байна.

2018 онд аймгийн ТЕЗ-ийн хэмжээнд нийт 65,369.4 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөж, батлуулснаас 67,299.1 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, нийт орлого, санхүүжилтийн төлөвлөгөө 1,929.7 сая төгрөг буюу 3.0 хувиар давж биелсэн байна.

Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулиар аймгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2124.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр үндсэн тэнцэл 1,929.7 сая төгрөгийн ашигтай гарч улсын төсөвт 2,348.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн 2,348.1 сая төгрөгийн 224.0 сая төгрөг нь урьд оны дутуу төвлөрүүлэлт байна.

Аймгийн ИТХ-аар Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 3,628.6 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 3529.7 сая төгрөгийг төвлөрүүлэн 98.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Д/д	Сумын нэр	Төвлөрүүлэх орлого	/ мян.төг /
-----	-----------	--------------------	-------------

	<i>Бат/төсөө</i>	<i>төвлөрүүлсэн санхүүжилт</i>	<i>Зөрүү /Илүү -, Дутуу+ /</i>
Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого			
1 Өргөн	70,064.20	-	70,064.20
2 Замын-Үүд	3,558,567.80	3,529,691.95	28,875.85
<u>Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын дүн</u>	<u>3,061,607.80</u>	<u>3,628,632.00</u>	<u>98,940.05</u>
Улсын төсөвт төвлөрүүлэх орлого			
1 Улсын төсөвт төвлөрүүлэх	2,124,099.80	2,348,099.80	224,000.0
<u>Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын дүн</u>	<u>2,124,099.80</u>	<u>2,348,099.80</u>	<u>224,000.0</u>

Өргөн сумын түгээмэл тархацтай ашиг малтмалын төлбөр тасарч аймагт төвлөрүүлэх орлогыг 70.0 сая төгрөгөөр, Замын үүд сумын бусад татвар болон татварын бус орлого 294.6 сая төгрөгөөр тасарч 28.8 сая төгрөгийг аймагт дутуу төвлөрүүлсэн болно.

2018 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 30,907.7 сая төгрөг, ОНХС-гийн санхүүжилт 3,275.6 сая төгрөг, нийт 34,183.3 сая төгрөгийн орлогыг улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг хийхээр төлөвлөж, 100% буюу бүрэн санхүүжсэн байна.

Тайлант онд Ахмадын тухай хуулийн дагуу төрийн сангийн дансанд төсөвт байгууллагын 42 ахмадын санг байгуулан төсвөөс 101.7 сая төгрөгийн санхүүжилт олгож тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн нийт орлого нь орон нутгийн төсвөөс 26,847.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 30,732.9 сая төгрөг, ОНХС-гийн санхүүжилт 3,278.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 916.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 534.3 сая төгрөгөөс тус тус бүрдсэн байна.

Байгууллагуудын Нэмэлт дансаар нийт 3,181.0 сая төгрөгийн орлого төвлөрч бүртгэсэн байна.

2018 онд орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 27,818,1 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 28,466.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 2.3 хувиар буюу 700.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Татварын орлогын нэр төрлөөр ангилан харуулбал:

Орлогын нэр төрөл	Төл	Гүйц	Хэтрэлт/ хэмнэлт	Биелэлт ийн хувь
<u>Нийт орлого ба тусламжийн дүн</u>	<u>27,815,084.8</u>	<u>28,466,202.2</u>	<u>700,202.7</u>	<u>102.3</u>
<i>Татварын орлого</i>	<i>20,639,439.2</i>	<i>21,911,658.7</i>	<i>1,272,219.5</i>	<i>106.2</i>
Хувь хүний орлогын албан татвар	15,047,023.0	16,580,141.4	1,533,118.4	110.2
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	11,900,000.0	12,824,454.5	924,454.5	107.8
Үйл ажиллагааны орлого	2,002,874.4	2,178,752.0	175,877.6	108.8
Шууд бус орлого	1,144,148.6	1,576,934.9	432,786.3	137.8
Хөрөнгийн албан татвар	1,362,035.0	1,360,605.0	-1,430.0	99.9
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	670,000.0	717,773.7	47,773.7	107.1

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	660,000.0	609,034.3	-50,965.7	92.3
Бууны албан татвар	32,035.0	33,797.0	1,762.0	105.5
Бусад татвар, төлбөр, хураамж	4,230,381.2	3,970,912.3	-259,468.9	93.9
Улсын тэмдэгтийн хураамж	2,257,051.5	2,046,005.7	-211,045.8	90.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	866,523.3	689,624.2	-176,899.1	79.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	282,496.1	282,186.1	-310.0	99.9
Газрын төлбөр	460,000.0	514,427.7	54,427.7	111.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	136,927.5	136,927.5	0.0	100.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	227,382.8	301,741.1	74,358.3	132.7
<i>Татварын бус орлого</i>	7,175,645.6	6,554,543.5	-572,016.8	91.3
Нийтлэг татварын бус орлого	3,162,301.2	3,272,803.3	159,587.4	103.5
Торгуулийн орлого	1,480,164.4	1,509,112.7	28,948.3	102.0
Түрээсийн орлого	25,000.0	63,564.0	38,564.0	254.3
Бусад орлого	1,181,085.0	1,275,392.5	94,307.5	108.0
Бусад татвар	400,000.0	397,767.6	-2,232.4	99.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	76,051.8	26,966.5	-49,085.3	35.5
Хөрөнгийн орлого	4,013,344.4	3,281,740.2	-731,604.2	81.8
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	435,644.4	175,910.9	-259,733.5	40.4
Дуудлага худалдаа	3,577,700.0	3,105,829.3	-471,870.7	86.8

Тайлант онд орон нутгийн орлогоос 834.5 сая төгрөгийн ХХОАТ-ын буцаан олголт хийгдсэн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг аймаг болон сумдаар дараах хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	/ мян.төг / Биелэлтийн хувь
1	Айраг	60,720.0	63,817.5	3,097.5	105.1
2	Алтанширээ	71,584.0	74,754.5	3,170.5	104.4
3	Даланжаргалан	296,524.4	308,978.1	12,453.7	104.2
4	Дэлгэрэх	44,048.8	42,083.6	(1,965.2)	95.5
5	Иххэт	63,421.7	64,210.9	789.2	101.2
6	Мандах	69,873.5	73,283.9	3,410.4	104.9
7	Өргөн	416,449.0	335,768.7	(80,680.3)	80.6
8	Сайхандулаан	26,558.0	23,370.2	(3,187.8)	88.0
9	Улаанбадрах	43,540.0	46,052.0	2,512.0	105.8
10	Хатанбулаг	217,335.4	221,823.7	4,488.3	102.1
11	Хөвсгөл	45,520.0	63,843.3	18,323.3	140.3
12	Эрдэнэ	82,999.9	85,892.3	2,892.4	103.5
13	Сайншанд	1,607,491.0	1,588,839.8	(18,651.2)	98.8
14	Замын-Үүд	6,217,999.5	6,187,123.5	(30,876.0)	99.5
15	Санхүү хэлтэс	18,551,019.6	19,286,360.2	735,340.6	104.0
Нийт дүн		27,815,084.8	28,466,202.2	651,117.4	102.3

Хүснэгтээс харахад: орон нутгийн орлогын төлөвлөгөө 5 суманд 1.9-80.7 сая төгрөгөөр тасарч, аймгийн төв болон 9 суманд 0.8-735.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналтай холбоотой нийт 68,127.3 сая төгрөгийн бүртгэлийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

6.11. Зардлын бүртгэл, тайлагнал

Анх аймгийн ИТХ-аас 2018 оны төсвийг 61443.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2018 оны 12 дугаар сард төсөвт тодотгол хийж 2,136.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зарлагын хэмжээг 63,580.1 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 61,826.3 сая төгрөг зарцуулж, 1,753.8 сая төгрөгийн хэмнэлттэй гарч, улсын болон орон нутгийн төсөвт 437.6 сая төгрөгийг үлдэгдлийг төвлөрүүлсэн байна. Үүний 31,109.4 сая төгрөг нь орон нутгийн төсвийн, 30,716.9 сая төгрөгийн зарлага нь тусгай шилжүүлгийн байгууллагуудын зарлага байна.

Тайлант онд нэмэлт дансаар 3,181.0 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагууд 2,273.7 сая төгрөгийг, боловсрол, соёл, урлагийн салбарын байгууллага 541.8 сая төгрөгийг, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар 103.2 сая төгрөгийг, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 138.7 сая төгрөгийг, ГХБХБГ 123.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

6.9.1. Орон нутгийн нөөц хөрөнгийн талаар

Аймгийн ЗДТГ-ын 2018 оны төсөвт "орон нутгийн нөөц хөрөнгө" гэсэн зориулалтаар 800.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, Засаг даргын захирамжаар 796.6 сая төгрөгийг зарцуулжээ. Аймгийн ЗДТГ-ын нөөц хөрөнгийн зарцуулалтыг авч үзвэл төсөвт байгууллагуудад 60.3 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг, зочид төлөөлөгчид хүндэтгэл үзүүлэхэд 44.9 сая төгрөг, сургалт зөвлөгөөнд 84.9 сая төгрөг, шагнал урамшилд 107.4 сая төгрөг, урлаг спортын уралдаа тэмцээний дэмжлэгт 83.3 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 30 хувь буюу 240.0 сая төгрөгийг нөөц болгож үлдээлгүй тайлант онд зарцуулсан, улс, орон нутгийн төсвийн байгууллагуудад 60.3 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг үзүүлсэн нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан ЗД-ын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 5.1-д "Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно" гэж заалтыг зөрчсөн байна. тушаалыг зөрчсөн байна.

Аймгийн ИТХурал "орон нутгийн нөөц хөрөнгө" гэсэн зориулалтаар 100.0 сая төгрөгийг, Замын Үүд сумын ИТХурал 61.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын ангилалд батлуулж зарцуулсан байна.

Аймгийн болон Замын Үүд сумын ИТХурлын төсвийн захирагч нөөц хөрөнгийн зориулалтаар хөрөнгө зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийг зөрчиж байна.

6.9.2. Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Аймгийн ОНХС-ийн 2018 оны эх үүсвэрийг 3,505.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүний 3,275.6 сая төгрөг нь нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг, 60.1 сая төгрөг нь өмнөх оны үлдэгдлээс, 170.0 сая төгрөг нь зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээс бүрдэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр ОНХС-аас 3,275.6 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 170.0 сая төгрөг, хандив тусламжаар 153.8 сая төгрөг нийт 3,599.4 сая төгрөгийн орлого

төвлөрсөн байна. Үүнээс сумдын СХС-д 941.3 сая төгрөг, Сайншанд сумын Тохижилтод 155.2 сая төгрөг, Мал эмнэлгийн үйл ажиллагааны зардалд 124.9 сая төгрөгийг тус тус олгож, аймгийн ОНХС-аас 7 ажилд 1,754.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ОНХС-ийн данснаас ОНХО-ын дансанд залруулах бичилт хийхдээ 34.1 сая төгрөгийг илүү залруулсан бөгөөд түүнийг авлагаар тусгаагүй байна.

6.9.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар

Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 6,425.7 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 6,170.3 сая төгрөг зарцуулсан байна. Мөн Замын сангийн хөрөнгөөр 690.0 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 679.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг нэр төрлөөр авч үзвэл барилга байгууламж шинээр барих, засварлах ажилд 3,852.3 сая төгрөг, авто тээврийн хэрэгсэл худалдан авахад 120.4 сая төгрөг, хөрөнгө бэлтгэх болон бусад зардалд 2,877.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд “бусад ангилалдаагүй нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 656.6 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс зарцуулахаар төсөв батлуулж, байгууллагуудад 418.0 сая төгрөгийн 2 автомашин, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудад 238.6 сая төгрөгийг хөрөнгө худалдан авах нэрээр дэмжлэг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24 дахь заалтыг зөрчсөн байна.

6.12. Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгдсэн ТШЗ-ийн 64 тайланд зөрчилгүй, 19 ТШЗ-ийн тайланд хязгаарлалттай, 3 ТШЗ-ийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа. Мөн 10 ТТЗ-ийн тайланд зөрчилгүй, 4 ТТЗ-ийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

Мөн Нэгтгэл тайланд 6 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд 4 тайланд “Зөрчилгүй”, 2 тайланд “Сөрөг” санал дүгнэлт өглөө.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	64	19	0	3	86
2	ТТЗ	10	4	0	0	14
3	ОНӨААН	4	0	2	0	6
	Дүн	78	23	2	3	106

Аудитаар нийт 14,201.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 2,783.2 сая төгрөгийн алдааг залруулж, 116.1 сая төгрөгийн зөрчилд 46 төлбөрийн акт тогтоож, 6,834.6 сая төгрөгийн зөрчилд 46 албан шаардлага хүргүүлж, 18.4 сая төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 226 зөвлөмж өглөө.

Орон нутгийн төсвийн захирагчдын санхүүгийн аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

№	Байгууллагын ангилал	(мян төгрөг)							
		Зөрчил		Илрүүлэлт		Бүгд дүн		Залруулга	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	239	1,550.5	24	235.1	266	1,785.6	24	235.1
2	ТТЗ	22	1,057.5	27	2,548.1	51	3,605.6	27	2,548.1
3	ОНӨААН	57	8,810.7	-	-	57	8,810.7	-	-
	Дүн	318	11,418.7	51	2,783.2	370	14,201.9	51	2,783.2

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Залруулаагүй алдаа, зөрчил	(мян.төгрөг)											
		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт											
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТШЗ	239	1,550.5	42	101.4	32	794.9	165	635.7	-	-	1	18.4
2	ТТЗ	22	1,057.5	-	-	6	10.7	16	1,045.8	-	-	-	-
3	ОНӨААН	57	8,810.7	4	14.7	8	6,028.9	45	2,767.0	-	-	-	-
	Дүн	318	11,418.7	46	116.1	46	6,834.6	226	4,449.5	-	-	1	18.4

6.13. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга

Аудитаар аймгийн ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17,398.5 сая төгрөгийн цэвэрлэх бичилт, хоорондын тохируулга, илүү дутуу бүртгэсэн зөрчлийг залруулсан болно.

6.14. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайланд онд зөрчил дахин давтагдан гарсаар байна.

7. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулга нь холбогдох хууль тогтоомж, УСНББОУС болон тэдгээрт нийцүүлэн Сангийн сайдын баталж гаргасан заавар, журмуудын дагуу бэлтгэгдэж, материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

8. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

8.3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

8.3.1. Илрүүлэлт:

Аудитаар илэрсэн зөрчлийн 3043.4 сая төгрөгийн бүртгэлийн алдаа нь Төрийн сангийн бүртгэлтэй холбоотой байна. Аудитын явцад санхүүгийн тайлангуудыг зөрүүтэй бэлтгэсэн, сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү, алдангийн орлогыг дутуу тайлагнасан, өмнөх оны үлдэгдлийг зөрүүтэй тусгасан, буцаан төвлөрүүлсэн болон нэмэлт дансаар дамжуулсан орлогыг давхардуулан бүртгэсэн зэрэг зөрчил илэрсэн бөгөөд нийт 21,671.9 сая төгрөгийн залруулах бичилт хийлгэлээ.

Энэ нь УСНББОУС 1, Санхүүгийн тайлангийн толилуулгын 27 дугаар зүйлд "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг. УСНББОУС-ыг шаардлагатай үед нэмэлт тодотгол хавсралтуудын хамт хэрэглэх нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулах үр дүнд хүргэнэ" гэж заасныг, НББ-ийн тухай хуулийн 4.2.4-т "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж" улсын секторын НББ-ийн стандартыг заавал мөрдөнө гэсэн заалтыг зөрчсөн байна.

8.3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэн гаргахгүй байх, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх эрсдэлтэй

8.3.3. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан “мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа”-ны дагуу журнал хөтлөх.

8.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах тухай хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

8.4. Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарцуулалттай холбоотой:

8.4.1. Илрүүлэлт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас Хилийн цэргийн анги нэгтгэл болон улсын төсвийн байгууллагуудад нийт 102.0 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

8.4.2. Эрсдэл:

Төсвийг зохистой төлөвлөж, удирдах зарчим алдагдах

8.4.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байх тул цаашид хууль журам мөрдөж ажиллах

8.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах тухай хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

8.5. Орон нутгийн нөөц хөрөнгөтэй холбоотой:

8.5.1. Илрүүлэлт:

Аймгийн ИТХурал, Замын-Үүд сумын ИТХ “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын ангилалд нийт 161.0 сая төгрөгийг батлуулж зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралтад "Орон нутгийн нөөц хөрөнгө нь тухайн шатны Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зориулалттай" гэж зөрчсөн байна.

8.5.2. Эрсдэл:

Төсвийг зохистой төлөвлөж, удирдах зарчим алдагдах,

8.5.3. Өгсөн зөвлөмж:

Нөөц хөрөнгө нэрээр зарцуулагдаж байгаа зардлыг ангилан, тухайн шатны төсвийн зарлагад хамаарах Төсвийн эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, зарцуулах.

8.5.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах тухай хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

8.6. Орон нутгийн нөөц хөрөнгөтэй холбоотой:

Илрүүлэлт:

Засаг даргын нөөц хөрөнгөөс 30 хувь буюу 240.0 сая төгрөгийг нөөц болгож үлдээлгүй тайлант онд зарцуулсан, улс, орон нутгийн төсвийн байгууллагуудад 60.3 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралтад 2.3. "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана", 5.1-т "Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно" гэж заалтыг зөрчсөн байна.

8.6.1. Эрсдэл:

Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгөгүй болох эрсдэлтэй.

8.6.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.4-т "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба зарцуулаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна", 2.2.1.2-д "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

8.6.3. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах тухай хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09-р сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.